



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

**Эбола вируст халдвараас урьдчилан
сэргийлэх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 45/25 тоот зөвлөмж, Байнгын хорооны хуралдаанаар Эбола вируст халдвараас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцсэн дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Эбола вируст халдвараас урьдчилан сэргийлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т чиглэл болгосугай:

1/Эбола вируст халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор хүн амд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх ;

2/Эбола вируст халдвараас сэргийлэх, болзошгүй аюулын үед бэлэн байдлыг хангах сургалтад эрүүл мэнд, хил хамгаалах болон хилийн мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтнуудыг хамруулах, холбогдох байгууллагыг мэдээллээр шуурхай хангах ажлыг зохион байгуулах;

3/Эбола вируст халдварын сэжигтэй өвчтөнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, тусгаарлах эмнэлгийн бэлэн байдлыг хангах;

4.Эбола вируст халдвар, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдвартай өвчтөнийг тусгаарлах өрөөг хилийн 26 боомтод байгуулах, бэлэн байдлын нөөц бүрдүүлэхэд шаардагдах 8.389.320.000 /найман тэрбум гурван зуун наян есөн сая гурван зуун хорин мянга/ төгрөгийн зардлыг /тогтоолын хавсралтаар баталсан/ Засгийн газрын нөөц сангаас гаргах;

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Д.Батцогт/-нд үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Д.БАТЦОГТ

**Эбола вируст халдвар, шинэ болон дахин сэргэж буй халдварт
өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын нөөц
бүрдүүлэхэд шаардлагатай зардлын төсөв**

№	Нэр төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Термокамер	16	70 000 000	1 120 000
2	Халдваргүйтгэлийн пункт	21	324 000 000	6 804 000 000
3	Уураар ариутгах фумигатор	8	2 000 000	16 000 000
4	Халдваргүйтгэлийн мананцар үүсгэх машин	3	40 000 000	120 000 000
5	Тусгаарлах байр (иж бүрэн тоноглох)	17	14 600 000	248 200 000
6	Өвчтний тусгаарлах эмнэлэгт шаардагдах тоног төхөөрөмж	50	24 000 000	1 200 000 000
	Нийт			8 389 320 000